

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 10-р сарын 31-ний байдлаар


2018 оны 10-р сарын 31-ний байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 1.6 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.5 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 31-ний байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 5.7, үхрийн ястай махны үнэ 3.3 хувь, ямааны ястай махны үнэ 8.5 хувиар өссөн бол үхрийн цул махны үнэ 0.5 хувь, адууны ястай махны үнэ 3.8 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 3.0 хувь, үхрийн ястай махны үнэ 0.7 хувь, үхрийн цул махны үнэ 1.1 хувь, ямааны ястай махны үнэ 2.0 хувиар өссөн бол адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 10-р сарын 31-ний байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6780 төгрөг, үхрийн /ястай/ мах 8035 төгрөг, үхрийн цул мах 9430 төгрөг, адууны /ястай/ мах 5850 төгрөг, ямааны /ястай/ мах 5100 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг



Гурилын үнэ: 2018 оны 10-р сарын 31-ний гурилын үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 31-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй харин элсэн чихрийн үнэ өмнөх сараас 2 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 31-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 4.4 хувь, луувангийн үнэ 18.3 хувь, байцааны үнэ 7.6 хувь, хүрэн манжингын үнэ 7.8 хувиар буурсан бол, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногоос төмсний үнэ 6.3 хувь, луувангийн үнэ 2.8 хувиар өссөн бол, байцаа, хүрэн манжин болон сонгины дундаж үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 31-ний байдлаар савласан /1 литрийн/ сүүний үнэ өмнөх сараас 2.1 хувь, элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 1.3 хувь, задгай сүүний үнэ 6.7 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногоос /1 литрийн/ сүүний үнэ өөрчлөлтгүй бол элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.4 хувь, задгай сүүний үнэ 6.7 хувиар өссөн байна.

Ургамлын тосны үнэ болон цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.